

ARD





Үндэслэл

- Ард Санхүүгийн Нэгдэл нь Хөрөнгө Оруулагч Үндэстэнг цогцлоох эрхэм зорилгынхоо хүрээнд санхүү, даатгал, хөрөнгийн зах зээл, технологи, дэд бүтэц, блокчэйн, хэвлэл мэдээллийн салбарт үйл ажиллагаа явуулдаг 44 компанид хөрөнгө оруулж, 60 мянга орчим хувьцаа эзэмшигчтэй болсон байна.
- Ард Бит ХХК нь Ардын экосистемийг дэмжих зорилгоор 2019 онд АрдКойн урамшууллын оноог гаргаж өдгөө 540 мянга гаруй АрдКойн эзэмшигчтэй болж, 2019 оноос хойш нийт 4 сая гаруй удаагийн гүйлгээгээр 3 тэрбум АрдКойныг урамшууллаар харилцагчдадаа олгожээ.
- Ард Санхүүгийн Нэгдлийн хувьд урамшууллын оноо болох АрдКойноор өөрийн бүтээгдэхүүн үйлчилгээг авах, хөнгөлүүлэх, хөрөнгө эзэмших боломжийг олгодгоос гадна экосистемийн компаниуд зах зээл дээрээс буцаан татах, харилцагч нарт давуу тал бүхий олон боломжийг санал болгож түүний тодорхой хэмжээг шатаалт хийж үнэ цэнийг нэмэгдүүлэхийг эрмэлздэг билээ. Бидний АрдКойн эзэмшигчдэд нээж буй дараагийн боломж нь АрдКойноо хөрвүүлэн Ард Санхүүгийн Нэгдлийн хувьцааг эзэмших юм. Энэ нь бүтээгдэхүүн үйлчилгээ авч үнэгүй цуглуулсан АрдКойноороо тухайн санхүүгийн байгууллагын эзэн болох боломжийг нээж байна.



Токен танилцуулга

ARDT нь Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн (MSE:AARD) хувьцаатай 1:1 харьцаатай токен юм. АрдКойн эзэмшигчдэд АрдКойн урамшууллын оноогоор Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хувьцаа эзэмшигч болох боломжийг олгож байна. ARDT эзэмшигчид токеноо хүсвэл Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв (ҮЦТХТ)-ийн өөрийн дансанд байршуулах боломжтой.

Токен нэр	Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хувьцааны токен
Токен тикер	ARDT
Токен хэлбэр	Security token
Харьцаа	AARD1=ARDT1
Олборлолт	Олборлолт буюу майнинг хийх боломжгүй
Ногдол ашиг	MSE:AARD хувьцаатай адил ногдол ашиг авах эрхтэй

Токен гаргагчийн танилцуулга

- Ард Бит ХХК нь АрдКойн урамшууллын оноог гаргасан бөгөөд Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 100 хувийн хөрөнгө оруулалттай охин компани юм.
- Ард Санхүүгийн Нэгдэл нь санхүү ба технологийн компаниудад хөрөнгө оруулалт хийж, зах зээл дэх байр суурь, өрсөлдөх чадвар, үнэ цэнийг нь дээшлүүлэх замаар хувьцаа эзэмшигчдийнхээ хөрөнгийн өгөөжийг өсгөх зорилт тавин ажилладаг үндэсний санхүүгийн нэгдэл компани юм.

Алсын Хараа:

Бүс нутагтаа тэргүүлэгч финтек нэгдэл болох.

Эрхэм Зорилго:

Хөрөнгө Оруулагч Үндэстэнг цогцлооно.

Зорилт:



Нэгдсэн
Финтек
шийдэл



Бүтээлч
түйвээлт ба
тогтвортой
өсөлт



Салбаргүй,
цогц шийдэл



Хөрөнгө
оруулагч
үндэстэн



Олон улсад
гарах




Түүхэн замнал

И Ай Ти нь ХасБанкны хувьцаа эзэмшигчид болон удирдлагын багийн сонирхлыг ижилсүүлэх зорилгоор байгуулагдсан. 2013 онд ТэнГэр Санхүүгийн Нэгдлийн 30%-ийг эзэмшиж байсан. Аяллаа эхлүүлэхийн тулд 2013 онд дахин брендийг хийж, бүтцийн өөрчлөлт хийсэн.





Экосистем





Дижитал эринд банкны салбарыг дахин тодорхойлох нь - Ард Апп

МӨНГӨН ШИЛЖҮҮЛЭГ


- Банк хооронд
- Утасны дугаараар
- QR кодоор
- АТМ-аас бэлэн мөнгө авах

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛ

- Барьцаатай болон барьцаагүй цахим зээл
- Хугацаатай хадгаламж, итгэлцэл
- Тэтгэврийн хуримтлал

ДААТГАЛ

- Аяллын даатгал
- Тээврийн даатгал
- Эрүүл мэндийн даатгал
- Нөхөн төлбөр



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ


- МХБ-ийн арилжаа
- УБҮЦБ-ийн арилжаа
- Багцын удирдлага
- Зах зээлийн судалгаа

БУСАД

- Цахим худалдаа
- Блокчэйд суурилсан урамшууллын оноо
- Орон даяар хүргэлттэй
- Төлбөр тооцоо, амьдралын хэв маяг
- АрдКидс Аппын интеграци

Харилцагчийн өсөлт


ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ҮНДЭСТЭН




ХАРИЛЦАГЧДЫН СУУРЬ



АПП ХЭРЭГЛЭГЧ




ХАРИЛЦАГЧДЫН СУУРЬ




Тоон үзүүлэлт

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нийт хөрөнгө




Эздийн өмч




ОРЛОГЫН ТАЙЛАН

Цэвэр ашиг




Нийт дэлгэрэнгүй ашиг




ҮНЭЛГЭЭ

Хөрөнгө оруулалтын багц



Үнэлгээ



Тоон үзүүлэлт

	2020У4	2021У4	Өөрчлөлт	
Ард Апп хэрэглэгч	637,000	990,071	353,071	55.4%
АрдКидс хэрэглэгч		22,113	22,113	
АрдКойн эзэмшигч	286,117	516,425	230,308	80.5%
Зээлийн данс	37,694	47,303	9,609	25.5%
Даатгуулагч	166,509	235,470	68,961	41.4%
Тэтгэврийн хуримтлалын данс	10,447	100,600	90,153	863.0%
Үнэт цаасны данс	89,305	146,893	57,588	64.5%
ХЗХ-ны гишүүд	1,062	2,678	1,616	152.2%

	2020У4	2021У4	Өөрчлөлт	
AARD	4,523	19,034	14,511	4.2x
AIC	2,069	10,044	7,975	4.9x
ADB	2,139	13,484	11,345	6.3x
MNP	1,200	2,830	1,630	2.4x
ХОС	2,451	7,845	5,394	3.2x
BUN	5	2,307	2,302	461.4
ARDT		6,591	6,591	
TNGR		549	549	
Нийт	12,387	62,684	50,297	5.1x





Баталгаа

Харилцагчдын нийт ARDT токены дүнгээр Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн (MSE:AARD) хувьцаа 1:1 харьцаатайгаар Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв (ҮЦТХТ)-ийн Ард Бит ХХК-ийн нэр дээр бүртгэлтэй дансанд хадгалагдаж, хувьцааг тусгаарлах ажлыг Ард Секюритиз ҮЦК гэрээний үндсэн дээр хариуцдаг.



Мэдэгдэл

Энэхүү танилцуулгад АрдКойн эзэмшигчдэд өөрийн АрдКойноо ARDT токен руу хөрвүүлэх шийдвэр гаргахад туслах шаардлагатай мэдээллийг агуулахыг зорьсон болно.

АрдКойноо хөрвүүлэх нь хөрөнгө оруулалтын нэг хэлбэр бөгөөд хөрвүүлэлт хийхээс өмнө үүсэж болох эрсдлийг сайтар судалж, бодит мэдээ мэдээлэлд үндэслэн хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахыг зөвлөж байна.